

## ТАНИЛЦУУЛГА

*“Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх харилцааг зохицуулсан журмын төсөл боловсруулсан тухай*

Нийгмийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Нийгмийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах, анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх, тайлан гаргах журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам батлах тухай” А/182 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах журмыг баталж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 5574 дүгээрт бүртгүүлэн мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан. Дээрх хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх харилцааг зохицуулсан журмын төсөл болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл боловсруулав.

Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын сангийн төсөв, улсын төсөвт нэмэлт санхүүжилт, шинээр ажлын байр хүний нөөц нэмэх шаардлагагүй.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**